



**НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2015 оны 09 сарын 16 өдөр

Дугаар А/197

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 19/24 дүгээр тогтоолоор батлагдсан “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн 2.6.6, “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухай нийслэлийн Засаг даргын 2015 оны А/198 дугаар захирамж, тус газрын дүрмийн 2.3, 3.2.3, 3.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2015 оны аялал жуулчлалын арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан “УБ Арт Фэйр” дүрслэх урлагийн үзэсгэлэн зохион байгуулах ажлыг Монголын Урчуудын Эвлэлээр, арга хэмжээний маркетинг, сурталчилгааг Профайл ХХК-аар гэрээ байгуулан гүйцэтгүүлэхийг Эвент хариуцсан мэргэжилтэн /М.Болортуяа/-д даалгасугай.

2. “УБ Арт Фэйр” дүрслэх урлагийн үзэсгэлэн зохион байгуулах удирдамжийг хавсралтаар баталсугай.

3. Гэрээт ажлын төлбөр болох 4.500.000 /дөрвөн сая таван зуун мянган/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Э.БАТТУЛГА

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2015 оны 09 сарын 16 өдрийн
А/А/ тоот тушаалын хавсралт

**“УЛААНБААТАР АРТ ФЭЙР-2015” ДҮРСЛЭХ УРЛАГИЙН
ҮЗЭСГЭЛЭН ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ**

2015 оны 9 дүгээр сарын 15

Улаанбаатар хот

Нэг. Зорилго

Улаанбаатар хотын 376 жилийн ой, Дэлхийн аялал жуулчлалын өдрийг тохиолдуулан, “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн хүрээнд соёлын аялал жуулчлал, соёлын аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх, уран бүтээлчдэд дэмжлэг үзүүлэх, соёлын бүтээгдэхүүнийг эдийн засгийн эргэлтэд оруулах, аялал жуулчлалын улирлын хугацааг уртасгах, олон нийтэд урлагийн боловсрол олгох зорилгоор энэхүү арга хэмжээг зохион байгуулна.

Хоёр. Зохион байгуулагчид

Үзэсгэлэнгийн ерөнхий зохион байгуулагчаар нийслэлийн Аялал жуулчлалын газар, хамтран зохион байгуулагчаар Монголын Урчуудын Эвлэл, Пийпл Репаблик ХХК, дэмжигч байгууллагаар нийслэлийн Засаг даргын Тамгын газар тус тус ажиллана.

Гурав. Хамрах хүрээ


“Улаанбаатар Арт Фэйр-2015” дүрслэх урлагийн үзэсгэлэнд Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй урлагийн галерей, үзэсгэлэнгийн танхимууд, уран баримал уран дархны урлан, чөлөөт уран бүтээлчид дараах төрлүүдээр оролцох боломжтой. Үүнд:

- Уран зургийн бүх төрөл чиглэлийн бүтээл: Тосон будгийн зураг, монгол зураг, зураасан зураг, бар зураг, зохиомжит зураг, шог зураг, зурагт хуудас, судалбар зураг, уран бичлэг
- Уран баримал: баримал, холимог техник, инстоляци

Дөрөв. Хугацаа, зохион байгуулах газар

“Улаанбаатар Арт Фэйр-2015” дүрслэх урлагийн үзэсгэлэн нь 2015 оны 09 дүгээр сарын 25-наас 09 дүгээр сарын 30-ны өдрүүдэд Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй нийт галерей, зочид буудлуудад зохион байгуулагдана. Мөн энэ үеэр Улаанбаатар хотын төвийн хэсгээр байрлах 15 ширхэг мэдээлэл сурталчилгааны самбар дээр монголын шилдэг уран бүтээлчдийн бүтээлүүд тавигдах болно.

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2015 оны 09 сарын 16-дрийн
179 тоот тушаалын хавсралт



Тав. Төсөв

Үзэсгэлэн зохион байгуулахад шаардагдах зардлыг “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрөөс болон ивээн тэтгэгчийн хөрөнгөөр санхүүжүүлнэ. Үзэсгэлэнд оролцогчдоос төлбөр, хураамж, ногдол ашиг авахгүй.

Зургаа. Үр дүн

Гадаад, дотоодын жуулчид, цуглуулагчдын сонирхлыг татах олон улсын арга хэмжээтэй болж, аялал жуулчлалын улирлын хугацаа уртасна. Уран бүтээлчдэд бүтээлээ танилцуулан борлуулах боломжийг бий болгох, соёлын аялал жуулчлал, соёлын аж үйлдвэрлэл хөгжих, нийслэлийн иргэдэд урлаг, гоо зүйн боловсрол олгох, хотын соёлыг төлөвшүүлэхэд түлхэц үзүүлнэ.

-000-